

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРСГАМЖ

АЛТАН АРСГАМЖ

VOL.3

1/2000

1. ОЛОН УЛСЫН ТЕРРОРИЗМЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

МУИС, ОУХС-ийн багш
Д.Далайжаргал

1995 оны 6-р сард Канадын Галифакс "Их долоо"-гийн дээд хэмжээний ээлжилт уулзалт болсон билээ. Оросын холбооны улсыг оролцуулан "7+1 хэмээх томъёоллын доор явагдсан энэхүү уулзалт нь урьдын адилгаар санхүү-валют, худалдаа болгоод цэрэг, улс төр, аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэж зарим тохиолдолд өөрт ашигтайгаар тохиролцоонд хүрцгээж байсан хэдий ч "Их долоо"-гийн удирдагчид нэгэн зүйлийн эсрэг хамтран ажиллахаа санал нэгтгэйгээр илэрхийлж байсан бөгөөд энэ нь олон улсын терроризм юм.

"Хүйтэн дайн" дуусч, хоёр туйлт систем задарснаар дэлхийн улс орнуудад тэр дундаа посткоммунизмын орнуудад нүүрлэсэн нэг аюул бол энэхүү терроризмын асуудал юм. Ерөөс дан ганц посткоммунизмын орнуудад төдийгүй дэлхий нийтээр, олон улсын харилцааны глобал асуудал болсон юм.

Улс төрийн хүчирхийлэл буюу терроризм гэж юуг хэлэх вэ? Ямар учраас, юунаас болж террорист ажиглагаа гардаг вэ? Терроризмын аюул гэж юуг хэлэх вэ? Хүмүүс яагаад террорист байдаг вэ? зэрэг асуудлууд терроризмтой холбогдон зайлшгүй гарч ирдэг. Юуны урьд эдгээр асуултанд хариу өгч, ойлгож үзсэнээр терроризмын аюулын тухай, түүнтэй хийх тэмцлийн талаар ярих ёстой.

Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсаны 50 жилийн ойд, уг байгууллагын гишүүн орнуудаас гаргасан тунхаглалд: "Терроризмын бүх хэлбэр, илрэл болон үндэс хальсан зохион байгуулалт бүхий гэмт хэрэг, зэвсгийг хууль бусаар худалдах,

мансууруулах бодис худалдах, хэрэглэх зэрэг улс түмэнд учирч байгаа заналхийллийг арилгах зорилгоор хамтран ажиллахаа" нотолсон байна.¹

Улс гүрнүүд их төлөв дотооддоо арга хэмжээ авах замаар гэмт хэрэгтэй тэмцдэг.

Гэвч орчин үеийн зарим гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа ач холбогдол улам бүр өсч байна. Энэ нь нэг талаас олон улсын шинж чанар бүхий гэмт хэргийн төрөл, тоо улам бүр ихсэж байгаатай холбоотой юм. Нөгөө талаар ерөөс улс орнууд хамтран ажиллахыг шаарддаг, хоёр болгоод түүнээс дээш орнуудын оролцоотойгоор шийдвэрлэгддэг олон улсын гэмт хэрэг гэж байдаг. Үүнд ХХ зууны төгсгөл үеэс хамгийн элбэг болсон гэмт хэргүүд болох: Далайн дээрэм, боолчлол ба боолын худалдаа, эмэгтэйчүүд, хүүхдийн худалдаа, мөнгөн тэмдэгт хурамчаар үйлдэх, мансууруулах бодис хууль бусаар гүйлгэх, хүмүүсийг барьцаанд авах, агаарын хөлөг, усан онгоц булааж авах зэрэг гэмт хэргүүдийг багтаадаг.

Энэхүү олон улсын чанартай гэмт хэргүүдийн дотроос хамгийн аюултай бөгөөд улам газар авч байгаа нэг төрөл нь олон улсын терроризм билээ. Энэхүү гэмт хэрэг улс гүрнүүдийн тогтвортой байдлыг бусниулж олон улсын харилцааны хэвийн хөгжилд саад үзүүлдэг ноцтой хүчин зүйл болж хувирдаг байна.

Дайныг эс тооцвол олон улсын аллага шиг ноцтой улс төрийн хүчирхийлэл байхгүй. Дайны нэгэн адилгаар терроризм нь төрөл, хэлбэр, үйл явц, хамрах орон зайн хувьд ХХ зуунд өөрийн оргил үедээ хүрчээ. Учир нь ХХ зуунд энэхүү улс төрийн хүчирхийлэлд өртөгдөөгүй, терроризм гараагүй улс орон гэж бараг үгүй болсон. Энэхүү улиран одож буй ХХ зуунд хүн төрөлхтөн түүхэндээ хоёр их дайныг амсаж, үй олон хүний амь насыг бүрэлгэсэн бол үүний зэрэгцээ терроризмын аюул, түүний хүчирхийлэлд дайнаас дутахааргүй хүний амь, эд хөрөнгийг сүйтгэжээ.

1.1. Олон улсын терроризмыг тодорхойлох нь

"Терроризм" хэмээх үгийг анх нэр томъёо болгон хэрэглэсэн хүн бол Германы нэрт философич Эммануэль Кант юм. Тэрээр 1798 онд өөрийн зохиол бүтээлдээ уг нэр томъёог хэрэглэхдээ дэлхийн

улс гүрнүүд болоод хүн төрөлхтөний талаарх өөрийн гутрангуй үзлээ илэрхийлэхдээ хэрэглэн бичиж байв. Нийгмийн сөрөг үзэгдэл, түүний үр дагавраас болж хүний амь нас, эд хөрөнгө сүйрч буй үзэгдлийг "терроризм" хэмээн нэрлэж байжээ.²

Мөн онд Францын Академээс гарсан "Их тайлбар толь"-д нэр томъёог тайлбарлан бичсэн байх ба чингэхдээ бидний өнөө үед ойлгон хэрэглэдэг улс төр, олон улсын шинж чанар бүхий гэмт хэргийн утгаар бус харин 1789 оны хувьсгалын дараагаар Францын хувьсгалчдын явуулж байсан алан хядах ажиллагааг илэрхийлэн бичсэн байдаг.

Терроризм гэж чухам юу болох талаар, түүний мөн чанар, төрөл, зорилго, хамрах хүрээ, гарах болсон шалтгаан, террорист хөдөлгөөний үйл явц, арга хэрэгслэл, үр дагавар зэргийг тодорхойлох нь чухал асуудал юм.

Терроризмын талаарх тодорхойлолтууд янз бүр байдаг. 1936-1981 оны хооронд нийтдээ терроризмын талаар 109 янзын тодорхойлолт гаргаж иржээ.³

Эдгээр тодорхойлолтууд нь терроризмын төрөл хэлбэр, гарч буй учир шалтгаан, учруулж болох аюул зэргээс нь хамааруулан тодорхойлсон байдаг. Тухайлбал: "Терроризм гэдэг нь аливаа хүчирхийлэл бөгөөд энэхүү хүчирхийллийг үйлдэх, үйлдэхээр завдах, заналхийлэх явдал юм. Аливаа нэгэн зорилгод хүрэхийн тулд хийж буй тэмцлийн хэлбэр, стратеги болно" гэж тодорхойлсон бол Америкийн судлаач Пол Жонсын хэлснээр "Терроризм гэдэг нь улс төрийн ашиг хонжоо олох үүднээс гэм зэмгүй энгийн ард иргэдийн эсрэг зохион байгуулалттайгаар, санаатайгаар үйлдэж буй алан хядах, гэмтэл учруулах, тийнхүү үйлдэхээр заналхийлэх, айлгах явдал юм" гэжээ.⁴

Мөн судлаач Андрыо Пиерын үзэж буйгаар "Олон улсын терроризм гэдэг нь хүч хэрэглэх болоод хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, айлган сүрдүүлэх, ийм аргаар албадан шахах, ятган итгүүлэх болоод олон нийтийн анхаарлыг татах явдал юм" хэмээн тодорхойлжээ. Андрыо Пиерын үзэж буйгаар дэлхийн II дайны үед хот тосгодыг бөмбөгдөж олон мянган энгийн ард иргэдийг алсан, холбоотны цэргүүд, Президент агаараас цохилт өгсөн, Японы Хиросима, Нагасаки хотуудад цөмийн зэвсэг туршсан, улс төрийн гэмт хэрэгтнийг тамлан зовоох болоод цаазаар авах явдал, тэр ч

бүү хэл өөрийн сахилгагүй хүүхдээ шийтгэх, заналхийлэх зэрэг эдгээр бүхий л үйлдлүүд үйл ажиллагааг терроризм хэмээн нэрлэнэ" гэжээ.

1937 онд Женев хотноо болсон олон улсын бага хурлаас "Терроризмоос урьдчилан сэргийлэх болон тийм ажиллагааг цээрлүүлэн шийтгэх тухай" Конвенцийг баталжээ. Уг Конвенцид терроризмыг тодорхойлсон зүйл байхгүй бөгөөд харин доор дурдсан үйлдлийг терроризм хэмээн үзэж, цээрлүүлэн шийтгэвэл зохих тухай заажээ. Үүнд төрийн тэргүүн ба бусад зүтгэлтний биед халдах, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, олон хүний амь насанд аюул учруулах, алан хядах ажиллагаанд бэлтгэх ба турхирах, алан хядах хэрэгслээр хангах, хуурамч баримт бичиг шийтгэх зэргийг дурджээ.

Үүнээс үзэхэд терроризм хэмээх ойлголт нь алан хядах явдлаас өргөн утгатай, өөрөөр хэлбэл алан хядах явдал нь зөвхөн нэг илрэл болох нь тодорхой.

Олон улсын харилцааны түүхээс үзэхэд террористууд буюу алан хядагчид нь голчлон засгийн эрхийг авах, аливаа нийгэм, улс төрийн тогтолцоог сулруулах, эвдэх, төрөөс явуулж буй улс төр-эдийн засгийн арга хэмжээ, бодлогыг эсэргүүцэх зэрэг зорилгыг агуулж байдаг байна.

Иймд тэд нийгмийг аюултай, түгшүүртэй байдалд оруулж, улс оронд тогтворгүй, эмх замбараагүй байдал бий болгох, аливаа нөлөө бүхий, саад болж буй улс төр нийгмийн зүтгэлтнийг шахан зайлуулах, олон нийтийн санал бодлыг төөрөгдүүлэх, шахан хавчих бодлого явуулдаг байна.

Террористууд зэвсэгт халдлага болоод их хэмжээний аллага үйлдэх, үйлдэхээр заналхийлэх, барьцаанд авах, онгоц барьцаалах, эд хөрөнгийг хорлон сүйтгэх зэрэг нь хамгийн их дэлгэрсэн арга байдаг байна.

Терроризмын үйл ажиллагаа, үйл явцын хувьд авч үзвэл:

1.2. Олон улсын терроризмыг тодорхойлох аргууд

Терроризмыг тодорхойлох, түүний мөн чанарыг нь танин мэдэхэд олон талаас нь, хэд хэдэн хүчин зүйлээр нь шалтгаалан тодорхойлж, тайлбарласан явдал байдаг. Терроризмыг

ангилахдаа голдуу бүс нутаг, газар зүйн хүчин зүйлээр нь авч үзсэн байх юм. Үүнээс хамгийн элбэг байдаг нь 1) түүхийн талаас, 2) газар зүйн үүднээс, 3) гарал үүсэл, хэв шинжийн ангилал юм.

1) Түүхийн ангилал, ихэнх тохиолдолд терроризмыг түүхэн талаас нь, түүхийн үечлэлээр нь ангилан, тодорхойлсон байдаг.

1861 оноос Орос оронд популист хөдөлгөөн өрнөж, терроризм нь онолын хувьд анх бий болсон. Аливаа төр засгийн тэргүүн улс төрийн зүтгэлтний амь насыг өгүүтгэснээр нийгэмд өөрчлөлт шинэчлэл хийж, хүсэл зорилгоо гүйцэтгэж болох юм гэсэн үзэл буй болсон. ХХ зууны сүүл үеэс буюу 1881 оноос Оросын хаан II Александр, Италийн хаан I Умберто гэх зэрэг Оросын болон Европын хаадууд алан хядах нууц байгууллага, бүлэг хүмүүсийн гарт өртөх болов. Үүний оргил үе болох 1914 оны 6-р сарын 28-нд Сербийн алан хядах нууц байгууллагынхан Австри-Унгарын угсаа залгамжлагч хунтайж Франсуа Фердинандыг алснаар дэлхийн I дайн эхэлсэн. Энэ үеийг хүртэл терроризм нь голчлон төрийн эсрэг, улс орны эсрэг чиглэсэн байв.

Дэлхийн I-II дайн хүртэлх 40 жилийн хугацаанд төрийн терроризм буюу төрөөс зохион байгуулалтайгаар явуулсан терроризмын хэлбэр илүү давамгайлах болов. Энэ нь тэр үеэс бий болсон коммунист, фашист, нацист гэх мэт тоталитари дэглэмүүдтэй холбоотой юм.

Дэлхийн II дайнаас хойш өнөөг хүртэл хугацаанд төрийн терроризм, төрийн эсрэг терроризм гэсэн хоёр төрлийн терроризмын илрэл гарах болов. Үүнээс төрийн эсрэг терроризмын хэлбэр нь илүү давамгайлах шинжтэй болсон. Колонийн задрал, үндэстэн хоорондын мөргөлдөөн, шашны зөрчил гэх мэт улс орнуудыг хамаарсан үзэгдлүүд ихээр гарч ирсэнтэй холбоотой юм.

Энэ үеэс бий болсон нэг шинэ хэлбэр бол улс хоорондын терроризм юм. 40-өөд оны дунд үеэс цөмийн терроризмын аюулд хүргэж болох магадлал байсан билээ.

2) Газар зүйн ангилал

Үүнд газар зүйн хувьд хувааж үзсэн байдаг. а) Африк дахь үндэстэн хоорондын мөргөлдөөн; б) Латин Америк дахь империализмын эсрэг терроризм; в) Ойрхи Дорнодын хил хязгааргүй терроризм; г) Европ дахь хэт зүүний терроризм

3) Гарал үүсэл, хэв шинжийн ангилал

Терроризмын төрөл, гарал үүслийн хувьд янз бүрээр авч үздэг. Терроризмын хэв шинжийг ангилахдаа голдуу бүс нутаг, газар зүйн байрлалаар нь авч үзсэн явдал элбэг ажиглагдадаг. Гэвч эдгээр ангилаас хамгийн тохиромжтой, зарим талаар оносон ангилал бол түүний гарал үүсэл, хэв шинжийн ангилал юм. Өөрөөр хэлбэл гарч буй эх сурвалжаар нь ангилах явдал юм. Терроризмын үндсэнд нь дотоодын терроризм ба олон улсын терроризм гэж хоёр ангилж үзнэ. Үүнд:

Дотоодын терроризм нь

а) төрийн терроризм

б) төрийн эсрэг терроризм

а) Төрийн терроризм нь голдуу төрийн тогтолцоог бэхжүүлэх, эрх мэдлээ, засаглалаа хэвээр хадгалж үлдэх үүднээс өөрийн ард иргэд, тодорхой бүлэг хүмүүсийн эсрэг төрөөс явуулж буй алан хядах үйл ажиллагаа орно.

б) Дээрхийн эсрэг улгаар, төрийн тогтолцоог эвдэх, устгах үүднээс аливаа нийгэм дэх бүлэг хүмүүсээс төрийн эсрэг үйлдэж буй террорист ажиллагааг хамруулж үзнэ.

Олон улсын терроризм нь:

Терроризмын хэв шинжийн ангиллын нэг үндсэн төрөлд олон улсын терроризм багтдаг. Үүнд нэг улс орны хараат байдлаас ангижирч тусгаар төр улс байгуулахыг эрмэлзсэн колонийн эсрэг тусгаар тогтногч болоод салан тусгаарлагч талын тэмцэл, нөгөө талаар өөрийн колони болоод нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаа хэвээр хадгалан үлдэхийн төлөө, аливаа төр улсын зүгээс явуулж буй дээрхийн эсрэг шинж чанар бүхий террорист ажиллагааг багтаадаг.

Дэлхийн II дайны дараагаар олон улсын терроризмын хэлбэр болон салан тусгаарлагч болоод тусгаар тогтногч талын терроризм, колонизмын терроризмын хэлбэрүүд нь хамгийн ихээр гарах болсон юм. Терроризмын үйл явц нь улам их өргөн хүрээт хамаарч, олон улсын шинж чанартай болон хувирчээ. Энэ нь нэг талаас 1945 оноос хойш гарсан колонизмын задралтай холбоотой юм.

XVII зуунаас эхлэн тухайн үеийн Европын хүчирхэг гүрнүүд болох Нидерланд, Их Британи, Франц, Португали, Испани зэрэг

нь дэлхийг хуваах, нөлөөнийхөө хүрээг тэлэх тэмцэлд эхлэн орсон байна. Энэ үеийг олон улсын харилцааны түүхэнд "Европын эриний үе" хэмээн нэрлэдэг билээ. ХХ зууны эхэн үеэс энэхүү тэмцэлд Америкийн Нэгдсэн Улс, Хаант Орос, Япон орсноор Өмнөд Америк, Африк, Зүүн Өмнөд Ази, Ойрхи Дорнод гээд дэлхийд эдгээр орнуудын нөлөөний хүрээнд ороогүй бүс нутаг, газар гэж бараг үгүй болсон.

ХХ зууны дунд үеэс дэлхийн II дайны дараах колонизмын задралын үрээр бие даасан олон тусгаар улсууд төрж гарсан бөгөөд энэ нь хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой юм.

1. НҮБ байгуулагдсан ба уг байгууллагын нэг гол зорилго нь колонийн улсуудад тусгаар улс болоход нь туслах, дэмжлэг үзүүлэх явдал юм. Тиймээс ч дээрх зорилгоор Асрамжийн Зөвлөл хэмээх НҮБ-ын нэг гол байгууллага буй.
2. Дэлхийн II дайн эхлэхийн зэрэгцээ колонийн улсуудад тусгаар тогтнох, тусгаарлах хөдөлгөөнүүд гарах болсон.
3. Ерөөс Европын колоничлогч гүрнүүдийн хувьд колонийн улсууд нь эдийн засаг болоод улс төрийн хувьд ашиггүй болсон. Тийм ч учраас дайны дараа өөрийн колонийн улсуудаа яаран тусгаар тогтноулсан юм.

Улс төрийн тэмцлийн хэлбэр, арга нь боловсронгуй болж сайжирсны зэрэгцээ тусгаар тогтнох, төр улсаа байгуулах гэсэн үзэл санаанууд нь терроризмын үйл явцыг эрчимжүүлсэн юм. 1816 онд болсон Венийн энх тайвны бага хурлаар дэлхийд нийтдээ бие даасан суверинитет эрх бүхий 25 улс байсан бол дэлхийн I дайны дараагаар буюу 1919 онд 49, дэлхийн II дайны дараагаар буюу 1946 онд 66 болсон байна. 1958-1964 оны хооронд колонизмын задралын үрээр шинэ тусгаар тогтносон улсуудын тоо үлэмж хэмжээгээр нэмэгдсэн ба 80-122 болтлоо өсчээ. Өнөөгийн байдлаар НҮБ-ын мэдээлснээр 189 улс тусгаар оршиж, тус байгууллагын гишүүн болоод байна.⁶ Хамгийн эрчимтэй үе нь 1945-1975 оны хооронд буюу 64-155 болтлоо тусгаар тогтносон улсуудын тоо өссөн байна.⁷

Эдгээр бие даасан улсуудын цөөхөн хувь нь тусгаар тогтнолоо тайван замаар олж авсан байх бөгөөд бараг ихэнх улсууд нь бослого, зэвсэгт мөргөлдөөн, терроризм, партизаны дайн, бүх нийтийг хамарсан иргэний дайны замаар тусгаар тогтносон байна.

Өөрөөр хэлбэл терроризм хэмээх улс төрийн тэмцлийн хувьд нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа олж авах гэсэн тэмцэл үр дүнд бий болжээ. Үүний нэг тод жишээ бол Ирланд улс юм. 1922 онд олон улсын зэвсэгт тэмцэл, террорист ажиллагааны үр дүнд Өмнөд Ирланд нь Их Британаас тусгаар тогтносон бол өнөөдөр Умард Ирланд буюу Улстөр нь Өмнөдийн нэгэн адилгаар салан тусгаарлахын төлөө тэмцэж байгаа бөгөөд үүнээс үүдэж протестант болоод католик шүтлэгтнүүдийн хооронд гарсан олон тооны террорист үйлдлийн үр дүнд нийтдээ Ирландад 2200 хүн өртөн, амь үрэгдсэн байна. Их Британи улс нь терроризмын эсрэг тэмцэлд их хэмжээний мөнгө зарцуулсаар олон жил болов.

Зөвхөн Их Британид төдийгүй Европын бусад орнуудад террорист ажиллагаа нь гарсаар байна. Зөвхөн 1968-1978 оны хоорондох арван жилийн дотор Баруун Европт нийтдээ 757 удаа алан хядах үйл ажиллагаа гарсан ба үүнээс 478 нь Франц, Их Британи, ХБНГУ зэрэг Баруун Европын 4 гүрэнд гарсан байх ба энэхүү үзүүлэлт нь зөвхөн нэг жилийн дотор буюу 1974-1975 оны хоорондох үзүүлэлт юм.⁸

Олон улсын терроризмын энэхүү ангилалд хамрагдах нэг төрөл бол цөмийн терроризм юм. "Хүйтэн дайны" үед зэвсэглэлээр хөөцөлдөж байх үед цөмийн зэвсэгтэй хоёр их гүрэн болох АНУ, ЗХУ нь цөмийн зэвсгийн аюулаар хүн төрөлхтөний оршин тогтнохын аюулгүй байдлад сөргөөр нөлөөлж болохуйц байсан тэр үеийг хамруулж үздэг. 1950-иад оны эхээр АНУ-аас ЗХУ-ыг устгах зорилгоор зохиож, хэрэгжүүлэхэд бэлтгэж байсан. "Дропшот", "Троян" төлөвлөгөө⁹ 1950-1953 оны Солонгосын дайны үед Америкийн генерал Мак Артурын цөмийн зэвсэг хэрэглэх төлөвлөгөө, 1962 оны Карибын хямралын үед бий болсон нөхцөл байдал, 1983 оны "Европулжингийн хямрал" зэргийг хамруулж үздэг.

Гэхдээ энэхүү аюул бүрэн арилж, үгүй боллоо гэсэн үг хараахан биш юм. Зэвсэглэлээр хөөцөлдөх тэр тусмаа цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдал байсаар байна.

Олон улсын терроризмын тухай ярихад нэр томъёо болгоод агуулгын хувьд ялгаж ойлгох нэг зүйл бол "терроризм", "террор" хэмээх хоёр үгийн утгын тухай асуудал юм. Хэдийгээр энэхүү хоёр үг нь хоёулаа алан хядах, айлгана хэмээх утгыг илэрхийлдэг бол

хэрэглэх байдал, агуулгын хувьд хоёр өөр зүйл ажээ.

Нийгэмд тогтсон аливаа хуулийг зөрчиж, хуулийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааг /аллагыг/ "терроризм" хэмээх үг илэрхийлдэг бол нөгөө талаар төрөөс хуулийг хэтрүүлэн хэрэглэж "албан ёсны" болсон аллагыг "террор" хэмээн нэрлэдэг ажээ. Иймд "террор" үйлдэл гэдэг нь 1789 оны хувьсгалын дараа Францын хувьсгалчдын хийсэн аллага, 1973 онд төрийн эргэлтийн дараа тогтсон Август Пиночетын дэглэм, Камбож дахь "Улаан кхмерүүд"-ийн хийсэн геноцид буюу аймаглан устгалт зэргийг багтаан авч үздэг.

Төрөөс явуулж буй террор ажиллагаа нь ард түмний хувьд "албан ёсны" болон хуульчлагдсан явдлыг илэрхийлдэг ажээ. Тийм ч учраас Сталин ганц улсынхаа эзэн нь байж, айхтар хүнд сурталжсан, хуульчлагдан баталгаажуулсан төрийн ярихтай бүтцийн тусламжтайгаар засаглалаа хэрэгжүүлж байжээ.* Терроризм нь улс төрийн бодлоготой салшгүй холбоотой юм. Улс төрийн тэмцлийн нэг хэлбэр нь терроризм байдаг. Өөрөөр хэлбэл улс төрийн шинж чанартай, улс төрийн зорилгын үүднээс явуулж буй тийм ажиллагааг терроризм хэмээх нэр томъёогоор илэрхийлдэг ажээ.

Ийм ч учраас терроризм хэмээх үг нь улс төрийн бодлого, засаглал, ноёрхол, улс төрийн хүчирхийлэл, эсэргүүцэл тэмцэл гэсэн ойлголтуудыг үргэлж дагуулж байдаг.

Улс төрийн бодлоготой салшгүй холбоотой, түүний нэг илрэл болон гарч ирдэгийн хувьд аливаа террорист ажиллагаа нь үргэлж олон түмнийг хамарч байдаг байна. Өөрөөр хэлбэл терроризм нь бүлэг хүмүүсийн үйл ажиллагаа байдаг ажээ.

Олон жилийн турш судлаач, мэргэжилтнүүдийн ажиглаж судалснаар террорист хувь хүн гэж байдаггүй болохыг тогтоосон. Дээр дурдсанаар терроризм нь голдуу хэсэг, бүлэг этгээдийн үйлдэл байдаг аж. Нийгмийн гарал үүслийн хувьд тэд дунд түвшингийн, ихэнх нь дээд түвшингийн ухамсаржсан хэсгээс гаралтай байдаг. Террористууд ихэнхдээ 20-35 насны залуус байдаг ба тэд үзэл бодлын хувьд ихэвчлэн идеалистууд байж, нийгмийг үргэлж одоо байгаагаасаа илүү байх ёстой хэмээн боддог байна.* Ихэнх тохиолдолд террорист хөдөлгөөн нь өндөр хөгжилтэй орнуудад эрчимтэй явагддаг. Хөгжилтэй гэдэг нь зөвхөн

эдийн засгийн үзүүлэлтээр бус улс төр болоод тухайн ард түмний улс төрд оролцох идэвх, ухамсар зэргийг багтаан үздэг.

Дүгнэлт

Терроризм нь ХХ зуунд гарсан шинэ үзэгдэл биш юм. Галцхуу энэ зуунд терроризмын олон хэлбэр, илрэлүүд гарч ирсэн агаад терроризмд өртөгдөөгүй улс орон гэж байхгүй болсон юм.

Хүн төрөлхтөн үүсэн бий болсон тэр цагаас хойш терроризм гарч ирсэн юм. Хүний үндсэн зан авир болох бие биенээ удирдах, засаглах, дарангуйлах гэсэн зан араншин нь терроризм гарах үндсэн хүчин зүйл болсон юм.

Нийгмийн институтлагдсан бүтэц болох төр үүссэнээр терроризмын аливаа илрэл нь зохион байгуулалттай гарах болж улмаар нийгмийг хамрах шинжтэй болсон билээ.

Төрийг дээдлэх, төрийг шүтэх үзэл гарч ирсэний зэрэгцээ төрөөс явуулж буй бодлого, шийдвэрийг эсэргүүцэх, төрийн эсрэг хуйвалдах, төрийн тогтолцоог нураах гэсэн үзэл санаанууд гарч ирэн терроризмыг үйл ажиллагааныхаа зорилгыг болгох явдал ХХ зууны эхэн үеэс гарч ирэх болов.

Терроризм гэж юу болох, ямар шалтгаанаас болж гардаг нь тусгаар тогтнох, салан тусгаарлах тусгаар тогтнох үйл явц, хувьсгалт хөдөлгөөн, колонизмын эсрэг тэмцэл зэрэг улс төрийн үйл явцтай салшгүй холбоотой байна.

1914 оны 6-р сарын 28-нд Сербийн үндсэрхэг үзэлтнүүд Франсуа Фердинандыг алснаар терроризм нь зөвхөн улс орны дотоод хэрэг байхаа нэгэнт больж, хил хязгаараас халин гарч олон улсын шинж чанартай болов. Дэлхийн I дайнаас II дайныг хүртэл терроризм нь олон улсыг хамарсан нийтлэг үзэгдэл болов. Коммунист, фашист, нацист г.м. төрийн тоталитар дэглэмүүд нь баттай оршин тогтнохын тулд үй олон хүний амь насыг егүүтгэжээ.

Дэлхийн II дайнаас хойш колонизмын задралын үрээр олон арван улс орнуудад салан тусгаарлах хөдөлгөөнүүд өрнөж, зэрэг зэрэг тусгаар тогтноцгоосон билээ. Бий болсон эдгээр улсуудын ихэнх хувь нь зэвсэгт тэмцэл, алан хядах замаар тусгаар тогтнолоо олж авав.

Терроризм нь зөвхөн улс төрийн бодлого, улс төрийн хүчин

зүйлээс шалтгаалах үзэгдэл биш юм. Шашны мөргөлдөөн, үндэстэн хоорондын асуудал, хар тамхины зөөвөр, арьс өнгөөр ялгаварлах үзэл г.м. нийгмийн хүчин зүйлээс шалтгаалан терроризмын олон янзын хэлбэрүүд гарч ирэх болов.

Терроризм гэдэг нь зөвхөн алан хядах, хорлон сүйтгэх ажиллагаа төдийхнөөр ойлгох нь хэт өрөөсгөл явдал юм. Шинжлэх ухаан, технологийн хөгжил, нийгмийн сэтгэхүйн, ухамсарын өсөлтийг даган терроризмын үйл явц нь улам их орон зайг хамарч, шинэ шинэ арга хэлбэртэй болов. Ингэснээр, терроризмын үйл явц нь бидний мэдэхгүй, төсөөлөөгүй салбарыг хамрах болсон юм. Иргэний агаарын тээврийн хэрэгсэл, усан онгоц барьцаалах, хэн нэгнийг галт зэвсгээр алах явдал нь 50-аад оны дунд үеэс гарах болж, тухайн үедээ шинэ үзэгдэл байсан боловч өнөө үед сонгодог арга байхаа нэгэнт больж, террористууд эдгээр аргыг хэрэглэхээ больсон билээ. Терроризмууд улмаар шинээр аргуудыг эрэлхийлэн, нээн илрүүлж, өөрсдийн үйл ажиллагаандаа хэрэглэх болов. Цахим тооцоолох хэрэгсэл, программын тусламжтайгаар нисэх онгоцны чиглэлийг өөрчлөх, хурдан галт тэргийг хооронд нь мөргөлдүүлэх, нийтийн орон сууцанд тэсрэх бөмбөг тавьж дэлбэлэх, цөмийн технологийг хульгайлах, хүн амын эсрэг ашиглах зэрэг үйлдлүүд нь алан хядагчдийн шинэ арга тактик болов.

Орчин үеийн олон улсын терроризмын нэг онцлог бол уг үзэгдэл хил хязгааргүй болсонд оршино. Хаана, хэдийд ч террористын аливаа ажиллагаанд өртөж болзошгүй. Террористууд өөрсдийн хүсэж буй зорилго санасандаа хүрч чаддаг болсон явдал болно.

Терроризмын эсрэг тэмцэл аль эрт XIX зууны сүүлээс эхэлсэн юм. 1937 онд анх Үндэстнүүдийн Холбооноос терроризмын эсрэг конвенц гаргаснаас хойш НҮБ болоод түүний төрөлжсөн байгууллагуудаас олон арван гэрээ конвенц баталсан билээ. Харамсалтай нь улам бүр өсөн нэмэгдэж буй энэхүү гэмт хэрэгтэй зөвхөн гэрээ, конвенц баталж, тогтоол шийдвэр гаргаснаар тэмцэж чадахгүй байна. Олон улсын терроризмын тэмцэлд улс орнуудын зүгээс идэвхитэй санал санаачилга, нэгдмэл ойлголт, практик ажиллагаа юу юунаас илүү чухал болгоод байна.

Хоёр туйлт систем задарснаар Зүүн Европын болоод бусад орнуудад гарсан өөрчлөлтүүдийг дагаад Монгол Улсад улс төр,

эдийн засаг, нийгмийн гүн гүнзгий өөрчлөлт гарав. Хэдийгээр сонгодог утгаараа манай улсад терроризмын аливаа илрэл гараагүй боловч нийгмийн бусад бүхий л үзэгдлийн нэгэн адилгаар манай улсыг дайрч гарах нь дамжиггүй юм. Олон улсын терроризмын эсрэг тэмцэлд гэрээ конвенцид нэгдэж ороод зогсохгүй хоёр хөрш болоод, дэлхийн бусад орнуудтай тодорхой салбарыг хамарсан хамтын ажиллагаа явуулах хэрэгтэй юм. Терроризмын талаар судалгаа шинжилгээ хийж, судлаач мэргэжилтэн солилцуулан сургах, шинэ техник технологи нэвтрүүлэх г.м. онолын болоод практик мэдлэгийн бэлтгэлтэй байх нь зайлшгүй болоод байна.

Ашигласан ном хэвлэл:

1. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, "Олон улсын эрх зүй" УБ, 1994, х 314
2. Luigi Bonaparte, "Le terrorisme international", Italie, 1994, р9
3. Steven L. Spiegel, "Politics in the World Arena", University of California, 1988, р 170
4. "Terrorism, Political Violence and World Order", ed. Henry Nuulwook Nan, University Press of America, N.Y, 1984, р 50
5. James Lee Ray, "Global Politics", Florida State University, 1987, р 386
6. Хамгийн сүүлд буюу 1999 оны 9 сарын 15-нд НҮБ-д шинээр 3 улс элсэж гишүүдийн тоо 189 хүрсэн байна
7. Daniel S. Papp, "Contemporary International Relations", 1988, р 28
8. Luigi Bonaparte, "Le terrorisme international", Castelman, Italie, 1994, р13
9. "Два курса, две политики", Спутник, 1 январь, 1995